



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2025.12.05 № 1017  
танай \_\_\_\_\_-ы № \_\_\_\_\_-т

### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БАТТУЯА ТАНАА

Төрийн аудитын байгууллагын 2025 оны төлөвлөгөөний дагуу “Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх”-д хийсэн нийцлийн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт 28 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ЗАСГИЙН ГАЗРААС  
ТОГТООСОН ХЯЗГААРЫГ БАРИМТЛААГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: "ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД САНАЛ ДҮГНЭЛТ ӨГӨХ"

АУДИТЫН КОД: ХЭА-2025/07-22-ШТА-НА

Хэрлэн сум 2025 он



Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх  
аудитор Ж.Ганбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: [ganbaatarj@audit.gov.mn](mailto:ganbaatarj@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 99775390 Цахим хаяг: [oyuntuyad@audit.gov.mn](mailto:oyuntuyad@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Эрдэнэбилэг, Г.Энх-Амгалан, Ц.Билэгсайхан

Аудитор: Н.Туяа, Х.Еркегүл, Б.Ариунаа, Б.Хуланхатан,  
Т.Алтаншагай, Н.Хэрлэнбаяр, Д.Эрдэнэтуяа, Х.Баярбаатар

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)



**Аудитыг гүйцэтгэсэн:**

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор  
Ж.Ганбаатар

Аудитын менежер  
Д.Оюунтуяа

Ахлах аудитор:  
Д.Эрдэнэбилэг  
Г.Энх-Амгалан  
Ц.Билэгсайхан

Аудитор:  
Б.Ариунаа  
Т.Алтаншагай  
Б.Хуланхатан  
Н.Хэрлэнбаяр  
Н.Туяа  
Х.Еркегүл  
Д.Эрдэнэтуяа  
Х.Баярбаатар

Аудитын тайлан,  
дүгнэлт, зөвлөмжтэй  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах, холбогдох  
саналаа өгөхийг хүсвэл  
70562112 дугаарын  
утсаар харилцана уу.

Аудитын тайланг УАГ-ын  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn) цахим  
хуудаснаас үзнэ үү.

Хаяг: Хэнтий аймаг дахь  
Төрийн аудитын газар

Хэрлэн сум, 4-р баг,  
аймгийн Засаг даргын  
Тамгын газрын байр

**АГУУЛГА**

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	6
<b>БҮЛЭГ 1. Төсвийн төслийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн, төсвийн хязгаарт багтаан төлөвлөөгүй байна.</b>	<b>9</b>
1.1. <i>Орон нутгийн төсвийг Засгийн газраас тогтоосон төсвийн хязгаарт багтаан төлөвлөөгүй байна.</i> .....	9
1.2. <i>Төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан шаардлагад бүрэн нийцүүлж боловсруулаагүй байна.</i> .....	9
<b>БҮЛЭГ 2. Төсвийн орлогыг 1,800.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.</b>	<b>10</b>
2.1. <i>УИХ-аас орон нутгийн төсвийн суурь орлогыг 37,367.5 сая төгрөгөөр баталсныг 4,641.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн төсөлд тусгасан байна.</i> .....	10
2.2. <i>Орон нутгийн төсвийн орлогын нөөцийг бүрэн тооцоолоолж төлөвлөөгүй байна.</i> .....	11
<b>БҮЛЭГ 3. Төсвийн зардлыг 340.1 сая төгрөгөөр бууруулж, төсвийн 6,682.4 сая төгрөгийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх боломжтой байна.</b>	<b>13</b>
3.1. <i>Төсвийн төсөлд тусгагдсан нийт зардлыг бууруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх боломжийг тооцоогүй байна.</i> .....	13
3.2. <i>Аймгийн 2026 оны төсвийн төсөлд төлөвлөлтийн шаардлага хангахгүй хөрөнгө оруулалтын 24 төсөл, арга хэмжээнд нийт санхүүжилтийн 34.6 хувь буюу 5,734.4 төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.</i> .....	18
<b>ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:</b>	<b>23</b>
<b>АУДИТЫН ДҮГНЭЛТ:</b>	<b>24</b>
<b>ЗӨВЛӨМЖ:</b>	<b>25</b>



## ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



### ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 11 дугаар сарын 27

Дугаар А/47

Чингис хот

#### Г Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд санал дүгнэлт өгөх” аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад хүргүүлсүгэй.
3. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Д.Оюунтуяа/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
АТБӨЯХ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэл
БОГ	Байгаль орчны газар
БТСГ	Биеийн тамир спортын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СХДАГ	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
УИХ	Улсын Их Хурал
ҮХХ	Үл хөдлөх хөрөнгө
ЭХЗЗ	Эрчим хүчний зохицуулах зөвлөл

**Хүснэгтийн товьёг**

<b>№</b>	<b>Тайлбар</b>	<b>Хуудасны дугаар</b>
<i>Хүснэгт 1</i>	<i>Төсөл, арга хэмжээний мэдээлэл</i>	<i>8</i>
<i>Хүснэгт 2</i>	<i>Батлагдсан төсвийн хязгаар</i>	<i>9</i>
<i>Хүснэгт 3</i>	<i>ААНОАТ-ын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>	<i>11</i>
<i>Хүснэгт 4</i>	<i>АТҮТ-д бүртгэлтэй тээврийн хэрэгслийн судалгаа</i>	<i>12</i>
<i>Хүснэгт 5</i>	<i>АТБӨЯХ-ийн албан татвар ногдуулсан судалгаа</i>	<i>12</i>
<i>Хүснэгт 6</i>	<i>Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан албан татварын судалгаа</i>	<i>13</i>
<i>Хүснэгт 7</i>	<i>Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг 2025 оны батлагдсан төсөвтэй харьцуулсан харьцуулалт</i>	<i>14</i>
<i>Хүснэгт 8</i>	<i>Орон нутгийн төсөвт байгууллагын цалингийн сангийн харьцуулалт</i>	<i>14</i>
<i>Хүснэгт 9</i>	<i>Түлш, халаалтын зардлын төсөвлөлтийн судалгаа</i>	<i>16</i>
<i>Хүснэгт 10</i>	<i>Тэтгэвэр, тэтгэмж, урамшууллын тооцоолол</i>	<i>16</i>
<i>Хүснэгт 11</i>	<i>Төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа</i>	<i>18</i>
<i>Хүснэгт 12</i>	<i>Шаардлага хангахгүй зураг, төсвийн ажлууд</i>	<i>19</i>
<i>Хүснэгт 13</i>	<i>Төсөл, арга хэмжээний зураг, төсөв магадлагдсан судалгаа</i>	<i>19</i>
<i>Хүснэгт 14</i>	<i>Магадлалын хугацаа дууссан төсөл, арга хэмжээ</i>	<i>20</i>
<i>Хүснэгт 15</i>	<i>Магадлалын ерөнхий дүгнэлт гараагүй төсөл, арга хэмжээ</i>	<i>20</i>
<i>Хүснэгт 16</i>	<i>Зураг төсөл, тоног төхөөрөмжийн ангиллын төсөл, арга хэмжээ</i>	<i>20</i>
<i>Хүснэгт 17</i>	<i>Сумын болон байгууллагын хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээ</i>	<i>21</i>
<i>Хүснэгт 18</i>	<i>Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний судалгаа</i>	<i>21</i>

**Дүрслэлийн товьёг**

<b>№</b>	<b>Тайлбар</b>	<b>Хуудасны дугаар</b>
<i>Дүрслэл 1</i>	<i>Орон нутгийн төсвийн орлого, санхүүгийн дэмжлэг, ОНХС-ийн өсөлт</i>	<i>10</i>
<i>Дүрслэл 2</i>	<i>Төсөл, арга хэмжээний төрөл</i>	<i>18</i>



**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2021 оны “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал” А/69 дүгээр тушаал, 2022 оны А/67 тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-ын дагуу гүйцэтгэв.

**Аудитын зорилт**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн өргөн мэдүүлсэн орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг аймгийн ИТХ-д хүргүүлэн, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэв.

Уг зорилтын хүрээнд дараах дэд асуудлуудад аудитыг чиглүүлэн хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- *Төсвийн төслийг Төсвийн тухай хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэх,*
- *Төсвийн орлогыг бодит тооцоо судалгаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тулгуурлан үндэслэлтэй төлөвлөсөн эсэх,*
- Төсвийн зарлагыг үр дүнд суурилсан арга аргачлалаар, хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх

**Аудитын хамарсан хүрээ**

Аудитад аймгийн төсвийн 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2025 оны батлагдсан төсөв, төсөвт хийсэн тодотгол, хүлээгдэж буй гүйцэтгэл, 2026 оны төсвийн төсөл, ТТЗ-д болон нэгжийн хэрэгжүүлэх арга хэмжээ, түүний хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд, санхүү, төсөвтэй холбоотой мэдээ мэдээллийг хамруулан хийж гүйцэтгэлээ.

**Аудитын арга зүй,**

Аудитыг АДБОУС -д нийцүүлэн батлуулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS6817:2020, “Төрийн аудит, тулгуур зарчим” MNS 6817-1:2020, “Төрийн аудитын Ёс зүйн дүрэм” MNS 6817-2:2020, “Төрийн аудитын чанарын хяналт” MNS 6817-3:2020, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS6817-5:2020, “Нийцлийн аудитын зарчим” MNS6817-6:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, аргачлалд заасанчлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглав.

**Шалгуур үзүүлэлт**

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай



**Аудит хийсэн багийн  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

**Хүндрэл бэрхшээл**

хууль

- Татварын ерөнхий хууль
- Татварын багц хууль
- Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам"
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"
- Сангийн сайдын 2021 оны 204 дүгээр тушаал загвар маягт батлах тухай
- Үндэсний хөгжлийн газрын даргын 2020 оны А/56 дугаар тушаалаар баталсан "Улсын хөрөнгө оруулалт хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах аргачлал"
- Алсын хараа 2050 бодлогын баримт бичиг
- Сангийн яамнаас ирүүлсэн 2026 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж, төсвийн хязгаар
- Хэнтий аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Хэнтий аймгийн 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө
- Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- МУЕА-ын 2022 оны А/59 дугаар тушаалаар батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл
- Өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилт

Аудитыг газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Эрдэнэбилэг ахлан, ахлах аудитор Г.Энх-Амгалан, Ц.Билэгсайхан, аудитор Н.Туяа, Х.Еркегүл, Б.Ариунаа, Б.Хуланхатан, Н.Хэрлэнбаяр, Т.Алтаншагай, Д.Эрдэнэтуяа, Х.Баярбаатар нар 2025 оны 09 дүгээр сарын 01-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэлээ.



## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хэнтий аймгийн 2025 оны төсөвт аймаг, сумын ИТХ-аар хэлэлцэн 1 удаа өөрчлөлт оруулж төсвийг 5,633.7 сая төгрөгөөр бууруулж 118,188.4 сая төгрөг болгон тодотгон баталсан байна.

Орон нутгийн төсвийн 2025 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр нийт орлого ба тусламжийн дүн 88,592.0 сая төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 81,964.0 сая төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл 6,628.0 сая төгрөгийн үр дүнтэй байна.

Орон нутгийн төсвийн орлого 10 дугаар сарын байдлаар 45,335.5 сая төгрөг буюу 123.3 хувийн биелэлттэй, зарлага 78.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хэнтий аймгийн 2026 оны төсвийг УИХ-аас 81,771.7 сая төгрөгөөр баталсныг 14,019.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 95,791.7 сая төгрөг болгон төсвийн төсөлд тусгасан байна.

Үүнээс сумдад олгох санхүүгийн дэмжлэг 25,165.5 сая төгрөг, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 19,238.7 сая төгрөгийг тус тус хуваарилж, сумаас аймгийн төсөвт өгөх татаасыг 12,075.8 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн байна.

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, их засвар, автозамын сан, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 27,323.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 51 төсөл, арга хэмжээг 16,565.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 1. Төсөл, арга хэмжээний мэдээлэл

сая төгрөг

д/д	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөл, арга хэмжээний тоо	Нийт төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
1	Орон нутгийн төсөв	14	7,037.9	4,116.8
2	Их засвар	12	4,985.7	2,442.2
3	Замын сан	2	1,867.9	1,867.9
4	ОНХСан	23	13,432.2	8,138.0
	<b>Нийт</b>	<b>51</b>	<b>27,323.7</b>	<b>16,565.0</b>

Аймаг дахь Төрийн аудитын газар орон нутгийн төсвийн 2026 оны төслийг аймгийн Засаг даргаас 2025 оны 11 дүгээр сарын 20-нд хүлээн авч, 7 хоногийн хугацаанд аудит хийн аудитын дүгнэлтийг аймгийн ИТХ-д 11 сарын 28-нд хүргүүллээ.

Аудитыг гүйцэтгэхэд аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын газраас ирүүлсэн ААНОАТ-ын ногдуулалт, өглөг, авлагын талаарх мэдээлэл нь баталгаажаагүй, мэдээллийн үнэн зөв байдал нь нотлогдохгүй, татварын тооцоо, судалгааны нотлох баримтыг ирүүлээгүй нь хүндрэлтэй байлаа.

**БҮЛЭГ 1. Төсвийн төслийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн, төсвийн хязгаарт багтаан төлөвлөөгүй байна.****1.1. Орон нутгийн төсвийг Засгийн газраас тогтоосон төсвийн хязгаарт багтаан төлөвлөөгүй байна.**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх”-д заасны дагуу Сангийн яамнаас орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж болон төсвийн хязгаарыг ирүүлсэн байна.

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр тогтоолын хавсралтаар Хэнтий аймгийн төсвийн суурь орлого 55,981.5 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 7,746.3 сая төгрөг, суурь зарлага 63,727.8 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 25,796.6 сая төгрөг буюу нийт орлого, зарлагын хязгаарыг 89,524.4 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Засаг дарга орон нутгийн төсвийн 2026 оны суурь орлогыг 38,133.3 сая төгрөг буюу 17,848.2 сая төгрөгөөр бууруулж, суурь зарлагыг 79,807.0 сая төгрөг буюу 16,079.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн Сангийн яаманд хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т “жилийн төсвийн хязгаарт багтаасан байх” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Хүснэгт 2. Батлагдсан төсвийн хязгаар

сая төгрөг

Үзүүлэлт	Төсвийн хязгаар	Хүргүүлсэн санал	УИХ-аас баталсан	Зөрүү
Төсвийн нийт орлогын дүн	89,524.4	105,603.6	81,771.7	(7,752.7)
Үүнээс: Суурь орлогын дүн	55,981.5	38,133.3	37,367.5	(18,614.0)
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	7,746.3	41,673.7	25,165.5	17,419.2
Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	25,796.6	25,796.6	19,238.7	(6,557.9)
Төсвийн нийт зарлагын дүн	89,524.4	105,603.6	81,771.7	(7,752.7)
Үүнээс: Суурь зарлагын дүн	63,727.8	79,807.0	62,533.0	(1,194.8)
Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	25,796.6	25,796.6	19,238.7	(6,557.9)

**1.2. Төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан шаардлагад бүрэн нийцүүлж боловсруулаагүй байна.**

Аймгийн Засаг дарга 2026 оны жилийн төсвийн саналаа 08 дугаар сарын 28-ны өдрийн 9/1776 тоот албан бичгээр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж shilendans.gov.mn системд байршуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2026 оны 11 дүгээр сарын 20-ны 9/2399 тоот албан бичгээр ирүүлсэн төсвийн төсөл нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасан:

- ✓ хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх



- ✓ жилийн төсвийн хязгаарт багтаасан байх
- ✓ худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргаж ирүүлэх шаардлагад нийцээгүй байна.

Иймд төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, холбогдох баримт материалыг хуульд заасан хугацаанд бүрэн ирүүлэхийг анхаарах шаардлагатай байна.

## БҮЛЭГ 2. Төсвийн орлогыг 1,800.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

### 2.1. УИХ-аас орон нутгийн төсвийн суурь орлогыг 37,367.5 сая төгрөгөөр баталсныг 4,641.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн төсөлд тусгасан байна.

УИХ-аас 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр 2026 оны Төсвийн тухай хуулиар Хэнтий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 25,165.5 сая төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 19,238.7 сая төгрөг, орон нутгийн төсвийн суурь орлогыг 37,367.5 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ нь өмнөх онтой харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 339.4 сая төгрөг буюу 1.0 хувиар, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 3,004.5 сая төгрөг буюу 18.5 хувиар тус тус нэмэгдэж, санхүүгийн дэмжлэг 2,140.3 сая төгрөг буюу 7.8 хувиар буурсан байна.

Дүрслэл 1. Орон нутгийн төсвийн орлого, санхүүгийн дэмжлэг, ОНХС-ийн өсөлт /сая төгрөг/



Аймгийн 2025 оны төсвийн нийт орлого ХБГ-ээр 53,215.6 сая төгрөгөөр биелэхээр бол 2026 оны суурь орлогыг 37,367.5 сая төгрөгөөр тогтоосон нь өнгөрсөн оноос 15,848.0 сая төгрөг буюу 29.8 хувиар бууруулж тогтоосон байна.

Аймгийн Засаг дарга орон нутгийн төсвийн төсөлд суурь орлогыг 4,641.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 42,008.6 сая төгрөгөөр төлөвлөж ирүүлсэн байна. Үүнд:

Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 4,621.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 25,375.0 сая төгрөг, Төсвийн байгууллагын өөрийн орлогыг 20.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 59.5 сая төгрөг байхаар тус тус төлөвлөсөн байна.



Орон нутгийн төсвийн орлогын төсөлд Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 25,803.4 сая төгрөгөөр төлөвлөсөн нь тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 1,103.2 сая төгрөг буюу 4.1 хувиар бууруулж төлөвлөсөн байна.

## 2.2. Орон нутгийн төсвийн орлогын нөөцийг бүрэн тооцоололж төлөвлөөгүй байна.

Аймаг дахь Төрийн аудитын газар 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан орлогоос дараах нэр төрлийн орлогын төлөвлөлтөд дүн шинжилгээ хийлээ.

### 1. Аж ахуй нэгжийн орлогын албан татвар:

ААНОАТ-ыг 2025 оны орлогын төлөвлөгөө 6,560.0 сая төгрөгөөр батлагдснаас оны эхний 9-р сарын гүйцэтгэлээр 6,560.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. ААНОАТ-ын төлөвлөгөө, гүйцэтгэл

сая.төгрөг

ҮЗҮҮЛЭЛТ	2023			2024			2025		2026			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /-тасарсах, +давсан/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /-тасарсах, +давсан/	Жилийн төлөвлөгөө	9-р сарын гүйцэтгэл	ХБГүйцэтгэл	Ирүүлсэн санал	Нэмэгдүүлэх санал	Нийт батлах дүн
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	4,650.0	2,594.5	(2,055.5)	2,240.0	4,736.4	2,496.4	6,560.0	6,560.0	6,560.0	5,000.0	-	5,000.0

ААНОАТ-ын хязгаарыг 5,000.0 сая төгрөгөөр хянасныг аймгийн 2026 оны төсвийн төсөлд өөрчлөлгүйгээр тусгасан байна.

ААНОАТ-ын орлогын эх үүсвэрийг үндэслэлтэй тооцож төлөвлөснөөр улсын төсвөөс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг хуульд заасан хувь хэмжээгээр бүрэн авах боломжтой байна.

### 2. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар:

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг 813.2 сая төгрөгөөр тооцон санал хүргүүлснийг Сангийн яам 123.2 сая төгрөгөөр бууруулж 690.0 сая төгрөгөөр хянасан байна.

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт 2022 онд 645.1 сая төгрөг, 2023 онд 692.8 сая төгрөг, 2024 онд 808.9 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг сүүлийн 3 жилд 130-147.4 хувиар давуулан биелүүлсэн байна. 2025 онд орлогын төлөвлөгөөг 808.0 сая төгрөгөөр баталснаас хүлээгдэж буй гүйцэтгэлээр 880.5 сая төгрөгийн орлого төвлөрөхөөр байна.

Автотээврийн үндэсний төвийн 2025 оны 09 сарын 25-ны өдрөөрх мэдээллийн санд бүртгэлтэй автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн мэдээллийг үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний есдүгээр хуралдаанаар баталсан “Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг тогтоох тухай” 04



дүгээр тогтоолын дагуу тооцоолж үзэхэд 2026 онд 1,191.8 сая төгрөгийн татварын орлого ногдуулахаар байна.

Хүснэгт 4: Автотээврийн үндэсний төвд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн судалгаа

№	Төрөл	Тоо	Ногдуулсан татварын мөнгөн дүн /сая төг/
1	Бүх төрлийн ачааны машин	6,022	262.4
2	Автобус	407	25.4
3	Суудлын автомашин	15,002	720.9
4	Мотоцикл	773	2.2
5	Тусгай зорилалтын автомашин	289	7.1
6	Трактор, өөрөө явагч бусад хэрэгсэл	197	3.6
7	Авто чиргүүл	648	170.2
8	<b>Нийт дүн</b>	<b>23,338</b>	<b>1,191.8</b>

УИХ-аар баталсан орон нутгийн 2026 оны АТБӨЯХ-ийн албан татварын орлогын төлөвлөгөөг дээрх ногдуулалттай харьцуулж үзэхэд 300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Хүснэгт 5: АТБӨЯХАТ ногдуулсан судалгаа

сая төгрөг

Татварын төрөл	2022 оны гүйцэтгэл	2023				2024				2025				Төсвийн төсөлд өгсөн санал	Сангийн яам хянасан	Нэмэгдүүлэх санал
		Ногдуулалт	Батлагдсан төсөв	2022 оны гүйцэтгэл	Ногдол, гүйцэтгэлийн зөрүү	Ногдуулалт	Батлагдсан төсөв	2024 оны гүйцэтгэл	Ногдол, гүйцэтгэлийн зөрүү	Ногдуулалт	Батлагдсан төсөв	Хүлээгдэж байгаа гүйцэтгэл	Ногдол, гүйцэтгэлийн зөрүү			
АТБӨЯХАТ	645.1	1,036.5	470.0	692.8	343.7	958.2	620.0	808.9	149.3	1,229.4	808.0	880.5	348.9	813.2	690.0	300.0

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Улсын бүртгэлд байгаа автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд тэдгээрийг ашиглаж байгаа эсэхийг үл харгалзан албан татвар ногдуулна” заасны дагуу ногдуулалтыг хийж, орлогыг бүрэн төвлөрүүлэх шаардлагатай байна.

Авто тээврийн үндэсний төвд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд ногдуулалтын тооцооллыг хийж, сүүлийн жилүүдийн төлөлт зэргийг үндэслэн АТБӨЯХ-ийн албан татварын орлогыг 300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

### **3. Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутгасан албан татвар:**

Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутгасан албан татварыг Сангийн яам 2026 онд 20,754.0 сая төгрөгөөр хянасныг 4,621.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 25,375.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төсвийн төсөлд тусгасан байна.

Дээрх орлогыг 2025 онд 22,580.3 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч төсвийн тодотголоор 1,302.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 23,883.1 сая төгрөгөөр баталснаас 10 дугаар сарын гүйцэтгэл, жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 3,023.5 сая төгрөгөөр давж биелэхээр байна.

Хүснэгт 6. Цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан албан татварын судалгаа/сүүлийн 3 жилээр/

сая төгрөг

№	2023 он	2024 он	2025 он
---	---------	---------	---------



	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /+биеллээгүй, -давсан/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /+биеллээгүй, -давсан/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Нийт ХБГ	Зөрүү /+биеллээгүй, -давсан/
								10-р сарын гүйцэтгэл	ХБГ		
1	11,960.8	15,807.6	(3,846.9)	17,097.3	22,087.7	(4,990.4)	23,883.1	22,591.3	4,315.3	26,906.6	(3,023.5)

Эрүүл мэнд, боловсролын салбарын албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх талаар УИХ-аас хэлэлцэн эцэслэн шийдвэрлээгүй, Сангийн яамнаас ирүүлсэн “Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл”-д цалин хөлсийг нэмэгдүүлэх асуудал тусгагдаагүй тул цалин хөлсний нэмэгдлээс орох орлогыг тооцоолоогүй болно.

*Цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг өмнөх онуудын гүйцэтгэл, тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэл зэрэгт үндэслэн 2026 онд 1,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөх боломжтой гэж үзлээ.*

**БҮЛЭГ 3. Төсвийн зардлыг 340.1 сая төгрөгөөр бууруулж, төсвийн 6,682.4 сая төгрөгийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх боломжтой байна.**

**3.1. Төсвийн төсөлд тусгагдсан нийт зардлыг бууруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх боломжийг тооцоогүй байна.**

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 4.3.2<sup>2</sup>-т заасан хугацаанд орон нутгийн төсөвт байгууллагуудын 2026 оны төсвийн төслийг холбогдох маягтын дагуу хүлээн авч хянан Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу нэмэлт тооцооллуудыг хийж, төсвийн урсгал зардлыг төсөв захирагч бүрээр төлөвлөсөн байна.

УИХ-аас орон нутгийн төсвийн /аймаг, сум/ нийт зардлыг 81,771.7 сая төгрөгөөр баталсныг аймгийн Засаг дарга 14,019.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 95,791.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Үүнээс аймгийн ИТХ-д өргөн барихаар боловсруулсан аймгийн төсвийн зардлыг авч үзвэл 4,633.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 56,991.3 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтыг 4,116.8 сая төгрөг, Засаг даргын үйл ажиллагааны зардлыг 2,112.5 сая төгрөг, дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийг 1,700.0 сая төгрөг, эрсдэлийн санг 700.0 сая төгрөг, аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны зардлыг 500.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, байгаль орчны газрын төсвийг 1,306.5 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн зарлагын 79 хувийг урсгал зардал, 21 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд зардлыг 95,791.7 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2025 оны батлагдсан төсөв 118,188.4 сая төгрөгтэй харьцуулж үзвэл нийт зардал 18.9 хувь буюу 22,396.7 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Үүнийг зардлын ангиллаар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт 7. Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг 2025 оны батлагдсан төсөвтэй харьцуулсан харьцуулалт* *сая төгрөг*



Зардлын ангилал	2025 оны төлөвлөгөө	2026 оны төсвийн төсөл	зөрүү(-буурсан, + өссөн)	хувь
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	27,577.8	25,803.4	(1,774.5)	-6.4%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,444.5	3,225.9	(218.6)	-6.3%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,236.2	21,612.7	(623.5)	-2.8%
Хангамж, бараа материалын зардал	1,571.8	897.2	(674.6)	-42.9%
Нормативт зардал	99.5	218.3	118.8	119.4%
Эд хогшил, урсгал засварын зардал	3,215.7	634.2	(2,581.6)	-80.3%
Томилолт, зочны зардал	883.3	464.3	(419.0)	-47.4%
Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,146.9	4,983.9	(8,163.0)	-62.1%
Бараа үйлчилгээний бусад зардал	7,435.0	5,265.3	(2,169.7)	-29.2%
Урсгал шилжүүлэг	1,542.9	1,506.4	(36.5)	-2.4%
Хөрөнгийн зардал	32,463.8	28,695.7	(3,768.1)	-11.6%

Дээрх хүснэгтээс харахад Нормативт зардлаас бусад зардал 2.4-80.3 хувь буюу 36.5 сая төгрөгөөс 8,163.0 сая төгрөгөөр буурсан байна. Тухайлбал:

- нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж 8,163.0 сая төгрөг,
- хөрөнгийн зардал 3,768.1 сая төгрөг,
- эд хогшил урсгал засварын зардал 2,581.6 сая төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардал 2,169.7 сая төгрөг,
- Цалин, хөлс болон нэмэгдэл урамшилын зардал 1,774.5 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

**Аудитын явцад дараах зардлыг бууруулж, үр ашгийг дээшлүүлэх боломжтой байна.**

#### 1. Цалингийн зардлын талаар:

УИХ-аас баталсан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд аймгийн суурь зарлагад туссан 24,191.4 сая төгрөгийн цалингийн зардлыг аймгийн Засаг дарга 1,612.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Сангийн сайдын 2025 оны 11 сарын 14-ны 01/10180 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралт “Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж”-д нийцээгүй байна.

Хэнтий аймгийн 2026 оны орон нутгийн төсвийн төсөлд цалингийн зардлыг дараах байдлаар нэмэгдүүлжээ. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 8: Орон нутгийн төсөвт байгууллагын цалингийн сангийн харьцуулалт

/сая төгрөг/

Байгууллагууд	2026 он		
	УИХ баталсан	Аймгийн батлуулах төсөл	Зөрүү
Сумын ЗДТГ	14,226.20	16,113.50	1,887.30
Сумын ИТХ	3,239.30	2,722.40	- 516.90
АИТХ	429.60	545.70	116.10
АЗДТГ	3,288.80	3,288.70	- 0.10
ХААГ	215.10	215.10	-
ОНӨГ	277.90	345.90	68.00
СХДАГ	322.70	404.80	82.10
БОГазар	1,819.20	1,629.10	- 190.10



Ой ангиуд	372.60	538.20	165.60
Дүн	24,191.40	25,803.40	1,612.00

- Аймгийн ИТХ, Байгаль орчны газар, Худалдан авах ажиллагааны газар, сумдын ЗДТГ, сумдын ИТХ-ын цалингийн зардлыг төлөвлөхдөө төрийн албан хаагчийн 1,836.3 сая төгрөгийн улирлын үр дүнгийн урамшууллыг тусгаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчдад урамшуулал олгох журам”-ын 1.1<sup>1</sup> дэх заалтад нийцэхгүй байна.
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн **28.1.Нутгийн захиргааны бүх шатны байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ: .. 28.1.14.нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор олон нийтийн байцаагч томилон ажиллуулах;** гэсэн заалтын дагуу 12 сумд олон нийтийн цагдааг томилон ажиллуулсан боловч дээрх хуулийн 46 дугаар зүйлийн 46.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулна, 46.5.8 “Олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалын зардлыг санхүүжүүлэх” заалтыг зөрчин 158.9 сая төгрөгийн цалинг тухайн байгууллагын төсвөөс олгосон байна. Үүнд:
  - Батноров сумын ИТХ-ын гэрээт ажиллагсдын цалингийн зардлаас 6.6 сая,
  - Хэрлэн сумын ИТХ гэрээт ажиллагсдын бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 101.5 сая,
  - Дэлгэрхаан сумын ИТХ гэрээт ажиллагсдын бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 9.9 сая,
  - Гурванбаян тосгоны ЗАА үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас 9.5 сая,
  - Батширээт сумын ЗДТГ үндсэн үйл ажиллагааны бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 4.6 сая,
  - Бэрх тосгоны ЗАА үндсэн үйл ажиллагааны бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 11.0 сая,
  - Мөрөн сумын ЗДТГ ЗДМХ-ийн бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 8.8 сая,
  - Дадал сумын ЗДТГ ЗДМХ-ийн бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 7.0 сая төгрөгийг олгожээ.

## 2. Түлш, халаалтын зардал

Халаалтын зардлыг 2025 онд 19,156.1 сая төгрөг баталж, төсвийн тодотголоор 2,071.9 сая төгрөгөөр бууруулж 17,084.1 сая төгрөгөөр баталсан байна. 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр түлш халаалтын зардал 16,276.9 сая төгрөгийг зарцуулж, 807.2 сая төгрөг хэмнэгдэхээр байна.

<sup>1</sup> Төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 51.1.4-т заасан мөнгөн урамшууллыг олгоход энэ журмыг мөрдөнө.1.2. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараахь эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно: 1.2.1. төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид; 1.2.2. төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид.1.3. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг төсвийн байгууллага жил бүр төсөвтөө тусгана”



Орон нутгийн 2026 оны төсөвт түлш, халаалтын зардлын төсвийг 18,366.4 сая төгрөгөөр Сангийн яаманд хүргүүлснээс 3,987.5 сая төгрөгөөр бууруулж 14,378.9 сая төгрөгөөр УИХ-аар баталсан байна. Үүнд:

Хүснэгт 9. Түлш, халаалтын зардлын төсөвлөлтийн судалгаа

/сая төгрөг/

	2024 оны гүйцэтгэл	2025 анх баталсан	Тодот госон	Тодот голоор хасагдсан	10 сарын гүйцэтгэл	ХБГ	Сангийн яамд хүргүүлсэн төсөл /2026 он/	УИХ-аар баталсан	Зөрүү	Орон нутгаас батлах төсөл	Өөрчлөл т
<b>Түлш халаалт</b>	15,349.8	19,156.1	17,084.1	(2,071.9)	12,046.2	16,276.9	18,366.4	14,378.9	3,987.5	17,256.9	2,878.0

УИХ-аас баталсан 2026 оны түлш халаалтын зардлын төсвийг аймгийн Засаг дарга 2,878.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 17,256.9 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүнд шинээр ашиглалтад орох барилга байгууламж, өргөтгөлийн халаалтын зардалд 2026 онд нийт 17 байгууллагад нийт 885.3 сая төгрөгийг нэмэгдүүлэн төсөвлөсөн байна.

Төсвийн төсөлд БТСГ-т 36.7 сая төгрөг, БОАЖГ-т 8.7 сая төгрөг, Биндэр сумын цэцэрлэгт 25.0 сая төгрөг, Норовлин сумын цэцэрлэгт 13.6 сая төгрөг, Бэрх тосгоны ЕБС-д 60.0 сая төгрөг, Батширээт сумын ЕБС-д 14.5 сая төгрөг, Мөрөн сумын ЕБС-д 7.2 сая төгрөг, Гурванбаян тосгоны ЕБС 5.2 сая төгрөг, нийт 170.8 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн байна.

Түлш, халаалтын зардлыг 2025 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэл, Эрчим хүчний сайдын тушаал, үнэ тариф, талбай, ирэх онд ашиглалтад орох барилга байгууламжийн эзлэхүүн зэрэг бодит тоо мэдээнд үндэслэн тооцож үзэхэд халаалтын зардлыг нийт 170.8 сая төгрөгөөр бууруулах саналтай байна.

### 3. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардалд 169.3 сая төгрөгийг үндэслэлгүй илүү төлөвлөсөн байна.

Урсгал шилжүүлгийн зардлын нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 176.1 сая төгрөг, бусад ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалд 19.8 сая төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалд 607.9 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 395.3 сая төгрөг, орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 65.2 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 242.1 сая төгрөг нийт 1,506.4 сая төгрөг төлөвлөсөн байна.

Хүснэгт 10. Тэтгэвэр, тэтгэмж урамшууллын тооцоолол

/сая төгрөг/

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	Төсвийн төслийн санал	Ирүүлсэн тооцоолол	Дахин тооцооллын зөрүү	Батлуулах санал
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	176.1	176.1		176.1
Бусад Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	659.8	19.8		19.8
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		607.9	155.8	452.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	437.1	395.3	13.6	381.7
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	64.6	65.2		65.2



Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	168.8	242.1		242.1
<b>Дүн</b>	<b>1,506.4</b>	<b>1,506.4</b>	<b>169.3</b>	<b>1,337.0</b>

Сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн 59 албан хаагчдад 607.9 сая төгрөгийг 2026 онд олгохоор төлөвлөснөөс өмнөх онуудад 7 албан хаагчид олгосон 88.4 сая төгрөгийг давхардуулан, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.” гэж заасныг зөрчиж 6 сумын Засаг даргын орлогчид 67.3 сая төгрөг үндэслэлгүй олгохоор, нийт 155.8 сая төгрөгийг илүү төлөвлөсөн байна.

Өндөр насны тэтгэвэрт гарах 11 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламжид 395.3 сая төгрөг төлөвлөснөөс Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын 3.2-т “Төрийн албанд ажилласан хугацааг тухайн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж буюу албан тушаалтан тооцож тодорхойлно. Төрийн албанд ажилласан хугацааг хуанлийн бүтэн жилээр тооцно.” гэж заасныг зөрчин 0.8 сая төгрөг, мөн дээрх тогтоолын 2.2-т “Төрийн албанд ажилласан нийт жилийн тоотой тэнцэх сарын тоогоор үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно. Төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн 36 сарын албан тушаалын үндсэн цалингийн дунджаас ихгүй байна.” гэж заасныг зөрчин 12.7 сая төгрөг, нийт 13.6 сая төгрөгийг илүү төсөвлөсөн байна.

*Урсгал шилжүүлгийн зардлаас үндэслэлгүй буруу тооцоолсон нийт 169.3 сая төгрөгийн зардлыг бууруулахаар байна.*

#### 4. Засаг даргын үйл ажиллагааны зардал

Хэнтий аймгийн 2026 оны төсвийн төсөлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт 2,112.5 сая төгрөгийн 94 арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнд:

- Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс 420.0 сая төгрөгийн 7 арга хэмжээ
- Цэргийн штаб 140.0 сая төгрөгийн 3 арга хэмжээ
- Хууль, эрх зүйн хэлтэс 188.5 сая төгрөгийн 15 арга хэмжээ
- Санхүү, төрийн сангийн хэлтэс 30.0 сая төгрөгийн 1 арга хэмжээ
- Нийгмийн бодлогын хэлтэс 891.5 сая төгрөгийн 36 арга хэмжээ
- Бүс нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс 422.5 сая төгрөгийн 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Дээрх хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ нь аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан боловч 948.0 сая төгрөгийн 28 арга хэмжээ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.4.б “үр дүнд чиглэсэн шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тооцож боловсруулсан байх” заасныг хэрэгжүүлээгүй суурь болон хүрэх түвшний үзүүлэлт, чанарын болон тоо хэмжээний шалгуур үзүүлэлт тодорхой бус байна.  
*/шаардлага хангаагүй арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар оруулав/*



Иймд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.4.б-д заасан шалгуурыг хангаагүй 948.0 сая төгрөгийн арга хэмжээний үр ашгийг дээшилүүлэх зөвлөмж хүргүүлж байна.

**3.2. Аймгийн 2026 оны төсвийн төсөлд төлөвлөлтийн шаардлага хангахгүй хөрөнгө оруулалтын 24 төсөл, арга хэмжээнд нийт санхүүжилтийн 34.6 хувь буюу 5,734.4 төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа 19 төсөл, арга хэмжээнд 6,333.3 сая төгрөгийг, шинээр хэрэгжүүлэх 15,214.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 төсөл, арга хэмжээнд 10,231.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа


сая.төгрөг

Д/д	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний тоо		Төсөвт өртөг		2026 онд санхүүжих дүн	
		Шинэ	Шилжих	Шинэ	Шилжих	Шинэ	Шилжих
1	Орон нутгийн төсөв	14		7,037.9		4,116.8	
2	Их засвар	9	3	3,531.1	1,454.6	2,189.4	252.8
3	Замын сан	2		1,868.0		1,868.0	
4	Орон нутгийн хөгжлийн сан	7	16	2,777.9	10,654.2	2,057.5	6,080.5
	<b>ДҮН</b>	<b>32</b>	<b>19</b>	<b>15,214.9</b>	<b>12,108.8</b>	<b>10,231.7</b>	<b>6,333.3</b>

Нийт санхүүжилтийн 70.2 хувь буюу 11,630.0 сая төгрөгийг барилга, байгууламж, 17.6 хувь буюу 2,915.2 сая төгрөгийг их засвар, 8.5 хувь буюу 1,414.7 сая төгрөгийг тоног төхөөрөмж, 3.7 хувь буюу 605.0 сая төгрөгийг зураг төслийн ажилд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Дүрслэл 2. Төсөл, арга хэмжээ төрөл

/сая төгрөг/





Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан 32 төсөл арга хэмжээнээс 5 төсөл, арга хэмжээ аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй, 11 төсөл, арга хэмжээ аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөтэй тус тус уялдаагүй байна. /Хавсралт 1-д үзүүлэв./

*Хөрөнгө оруулалтын 12 төсөл, арга хэмжээг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4-д заасан “орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй байна.*

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4-т заасан “Санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах” заалтыг зөрчин Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зураг төслийн 447.0 сая төгрөгийн 8 ажлыг багцлан 1 төсөл, арга хэмжээ болгон төлөвлөсөн байна.

Хүснэгт 12. Шаардлага хангахгүй зураг төсвийн ажлууд

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Зургийн даалгавар гарсан эсэх	2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх	АЗДҮАХ-т нийцсэн эсэх	Иргэдийн саналыг авч эрэмбэлсэн байдал
1	ОБГ-ын зураг төсөл	ЗД-2022/054			28
2	Дархан сумын ЕБС-ын барилга	ЗД-2023/08	42 дахь хэсэг	2.2.1.6.2.	
3	Залуус хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөө	ЗД-2025/018	3 дахь хэсэг	1.1.1.2.1	
4	67 айлын хаус хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөө	ЗД-2025/020	3 дахь хэсэг	1.1.1.2.1	
5	Нисэх хүртэлх 2,5 км автозамын зураг төсөл	ЗД-2024/011			28
6	Хүнсний ногооны зоорь		111 дэх хэсэг	3.2.5.1	
7	Орон сууцны хорооллын тохижилт, дээврийн засвар				28
8	Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө		9 дэх хэсэг	1.1.1.3.1	

Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасан зураг төсөл, хяналтын төсөвгүй 14 төсөл, арга хэмжээг 2026 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 13. ТАХ-ний зураг, төсөв магадлагдсан судалгаа

д/д	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ	Зураг төсөвтэй	Үүнээс		Магад лалаар батлагдсан зураг төсөвгүй
				Магадлалаар баталгаажсан	Хугацаа дууссан магадлалтай	
1	Орон нутгийн төсөв	8	1	1		7
2	Их засвар	9	5	5		4
3	Замын сан	1				1
4	Орон нутгийн хөгжлийн сан	3	1		1	2
<b>ДҮН</b>		<b>21</b>	<b>7</b>	<b>6</b>	<b>1</b>	<b>14</b>



Шинээр хэрэгжих барилга байгууламж, их засварын 7,205.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 3,774.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup>.2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2-т заасан “сүүлийн 2 жилийн хугацаанд хийсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл, төсөвтэй байх” шаардлагад нийцсэн бол 881.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний магадлалын ерөнхий дүгнэлтийн хугацаа дууссан байна.

Хүснэгт 14. Магадлалын хугацаа дууссан төсөл, арга хэмжээ

сая төгрөг

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эх үүсвэр	Төсөл арга хэмжээний ангилал	Хугацаа		Төсөл, арга хэмжээний	
				Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	2-р багт 2500кВа чадалтай 35/6кВа-ын дэд станц, 110/35/6кВа-ын Өндөрхаан дэд станцын өргөтгөл, 35кВа ЦДАШ, ЦДКШ-ийн угсралтын ажлын үргэлжлэл /Хэрлэн/	ОНХС	Барилга байгууламж	2026	2027	881.6	440.8
<b>ДҮН</b>						<b>881.6</b>	<b>440.8</b>

Зураг төсөл, хяналтын төсөв магадлалаар баталгаажаагүй 403.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний зураг төсөл, хяналтын төсөвт улсын магадлал хийлгэхээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн боловч аймгийн 2026 оны төсвийн төслийг аудитад хамруулах хугацаанд магадлалын ерөнхий дүгнэлтийг гаргаж ирүүлээгүй байна.

Хүснэгт 15. Магадлалын ерөнхий дүгнэлт гараагүй төсөл, арга хэмжээ

сая төгрөг

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эх үүсвэр	Төсөл арга хэмжээний ангилал	Хугацаа		Төсөл, арга хэмжээний	
				Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Соёлын төвийн гадна тохижилт (Хэрлэн сум)	ОНТ	Барилга байгууламж	2026	2027	403.5	282.4
<b>ДҮН</b>						<b>403.5</b>	<b>282.4</b>

Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журамд заасан төлөвлөлтийн шаардлагыг хангаагүй, магадлалаар батлагдсан зураг төсөвгүй 4,928.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 3,938.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 13 төсөл арга хэмжээг төлөвлөлтөд тусгажээ. /Хавсралт 1-д үзүүлэв./

Төсвийн төсөлд орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр 1,795.8 сая төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэй тоног төхөөрөмж худалдан авах, зураг төсөв боловсруулах 11 төсөл арга хэмжээнээс Засгийн газрын 278 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3.3 -т заасан “холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан ..... байх” шаардлагыг хангаагүй 440.0 сая төгрөгийн дүнтэй 5 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. /Хавсралт 1-д үзүүлэв/

Хүснэгт 16. Зураг төсөл, тоног төхөөрөмжийн ангиллын төсөл, арга хэмжээ

сая төгрөг

д/д	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөл арга хэмжээний тоо	Нийт төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
-----	-------------------------------	--------------------------	-------------------	------------------------



1	Тоног төхөөрөмж	10	1,348.8	1,348.8
2	Зураг төсөл	1	447.0	447.0
<b>ДҮН</b>		<b>11</b>	<b>1,795.8</b>	<b>1795.8</b>

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2-т заасан чиг үүргийн дагуу эрэмбэлэн үнэлж, нэн тэргүүний ач холбогдолтойг нь тодорхойлоогүй, тухайн сум ОНХС-ийн хөрөнгөөр, дээд шатны байгууллагын хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх боломжтой 404.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Хүснэгт 17. Сумын болон байгууллагын хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээ сая төгрөг

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эх үүсвэр	Хугацаа		Төсөл, арга хэмжээний	
			Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Аймгийн татварын хэлтсийн засвар	ОНТ	2026	2026	94.0	94.0
2	Мэдээлэл сургалтад ашиглах ухаалаг дэлгэц (ЭМДХ)	ОНТ	2026	2026	7.0	7.0
3	Аймгийн татварын хэлтсийн тоног төхөөрөмж	ОНТ	2026	2026	40.0	40.0
4	Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасагт шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил	ОНТ	2026	2026	38.0	38.0
5	Спорт цогцолборын тоног төхөөрөмж (Дадал сум)	ОНТ	2026	2026	32.0	32.0
6	Соёлын төвийн хэсэгчилсэн засвар (Дархан сум)	ОНТ	2026	2026	98.0	98.0
7	Ерөнхий боловсролын сургуулийн тоног, төхөөрөмж, Хэрлэн 4-дүгээр сургууль (Хэрлэн сум)	ОНТ	2026	2026	35.0	35.0
8	Цэвэр усны шугам сүлжээг хийн даралтаар цэвэрлэх компрессор /Чингис хотын ундны усны 41 км шугам сүлжээг цэвэрлэж иргэдийн эрүүл ахуйн хэрэглээний усаар хангана/	ОНХС	2026	2026	60.0	60.0
<b>Нийт</b>					<b>404.0</b>	<b>404.0</b>

Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup> дүгээр зүйлийн 29<sup>1</sup>.2.4 дэх хэсэгт заасан “урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.4.4 дэх хэсэгт заасан “төслийн зардлыг бүрэн тооцсон байх” шалгуурыг хангаагүй 1,216.8 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. /Хавсралт 1-д үзүүлэв./

Хүснэгт 18. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ сая төгрөг

Д/д	Зөрчлийн төрөл	Санхүүжих дүн	Тоо
1	Магадлагдсан зураг төсөлгүй ТАХ	3,938.6	13
2	Техникийн тодорхойлолтгүй ТАХ	133.0	3
3	Урсгал зардлыг тооцож төсөвт тусгаагүй	716.8	2
4	Бодлогын баримт бичигтэй нийцээгүй	946.0	6
<b>ДҮН</b>		<b>5,734.4</b>	<b>24</b>



Төлөвлөлтийн шаардлага хангахгүй хөрөнгө оруулалтыг төсвийн төсөлд тусгаж байгаа нь төсвийг үр ашиггүй зарцуулах, ашиглалтын шаардлага хангахгүй байх, төсөл, арга хэмжээний үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

### **Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт**

Төрийн аудитын байгууллага нь Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнө нь хийж гүйцэтгэсэн аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

Энэ нь өмнөх аудитын үр нөлөөг батжуулж, дараагийн аудитын чанар, үр нөлөөг сайжруулах нөхцөл болох бөгөөд аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилтот хэрэглэгчийг өмнө хийсэн аудитын тайлан болон тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн санах, дүгнэх боломж олгодог чухал ач холбогдолтой аудитын нэг үе шат юм.

Аймаг дахь Төрийн аудитын газар нь аймгийн 2025 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх 1,025.4 сая төгрөг, зардал бууруулах 2,298.2 сая төгрөг, төсвийн үр ашгийг сайжруулах 1,199.5 сая төгрөгийн санал дүгнэлт гаргаж, цаашид анхаарах асуудлын талаар аймгийн ИТХ-ын даргад 1, аймгийн Засаг даргад 8 зөвлөмж хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг даргад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн хариуг аймгийн ЗДТГ-ын 2025 оны 6 дугаар сарын 10-ны 9/1336 дугаар албан бичгээр тус тус ирүүлснийг үнэлэхэд хэрэгжилт 80.2 хувьтай байна. Үүнд:

- Аймгийн 2025 оны төсвийн төсөлд АТБӨЯХ-ийн албан татварын орлого, ҮХХ-ийн албан татварын орлого, сумын төсвөөс давсан орлого, ОНХС-ын эх үүсвэр, Малын тоо толгойн албан татварын орлогыг 1,025.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр хүргүүлсэн саналыг бүрэн хэрэгжүүлж орлогыг нэмэгдүүлэн баталж, хэрэгжилт 100.0 хувьтай,
- Аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны зардал болон тогтмол зардлыг 258.4 сая төгрөгөөр бууруулан баталж, байгаль хамгаалах нөхөн сэргээх 215.0 сая төгрөгийн ажлыг хууль, журамд нийцүүлэн боловсруулан баталж, зөвлөмжийг 100 хувьтай хэрэгжүүлсэн,
- Эрсдлийн сангийн зардал, малын халдварт өвчнөөс сэргийлэх зардал, хүүхэд хамгааллын зардал, шүүхийн шийдвэр барагдуулах зардлыг нийт 859.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн батлуулж 100 хувь хэрэгжүүлсэн бол Бэрх хот тохижилтод олгосон 340.0 сая төгрөгийн татаасын үр ашгийг дээшлүүлэх талаар хийсэн ажил тодорхойгүй байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ын санхүүжилтээр зураг төсөл, төсөвгүй, зураг төсөл, төсөвтэй боловч магадлалын ерөнхий дүгнэлтгүй, магадлалын ерөнхий дүгнэлтийн хугацаа дууссан зэрэг нийт 27 төсөл, арга хэмжээнээс 8,796.4 сая төгрөгийн 26 төсөл, арга хэмжээг хууль журамд нийцүүлэн батлуулж, зураг төсөвгүй 1 төсөл, арга хэмжээг баталсан боловч хэрэгжүүлээгүй байна. Хэрэгжилт 96.3 хувьтай байна.



**ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:**



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА**

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,  
Чингис хот, Хэнтий аймаг, 23000  
Утас/Факс: (976) 7056 2151,  
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn


2025. 11. 27 № 9/2447

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Хэнтий аймгийн “Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд санал, дүгнэлт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой саналгүй болно.



Д.АЮУРБУНЬ

231051055



## АУДИТЫН ДҮГНЭЛТ:

**Аймгийн Засаг даргаас ирүүлсэн 2026 оны төсвийн төсөлд аудитыг гүйцэтгэж төсвийн орлогыг нэмэгдүүлэх, зардал бууруулах, үр ашгийг дээшлүүлэх талаар дараах дүгнэлтийг гаргаж байна:**

Орон нутгийн төсвийг Засгийн газраас тогтоосон төсвийн хязгаарт багтаан төлөвлөөгүй байна.

Татварын орлогыг урьд онуудын татварын авлага, тайлант оны ногдуулалт, төсвийн орлогын гүйцэтгэл холбогдох мэдээлэл судалгааг үндэслэн бүрэн төлөвлөөгүй байна.

Орон нутгийн орлогыг 1,800.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, зарлагыг 340.1 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.

Төрийн албан хаагчдын 1,836.3 сая төгрөгийн улирлын үр дүнгийн урамшууллын зардлыг төлөвлөөгүй байна.

Олон нийтийн цагдаагийн ажилтны цалин, НДШ-ийн зардлыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу санхүүжүүлээгүй байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.4.б-д заасан шалгуурыг хангаагүй 948.0 сая төгрөгийн арга хэмжээг төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн санхүүжилтээр шинээр эхлүүлэх нийт 5,734.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй, 24 төсөл, арга хэмжээ буюу нийт санхүүжилтийн 34.6 хувь нь төлөвлөлтийн шаардлагад нийцээгүй байна.

Төсвийн тухай хууль болон холбогдох журамд нийцээгүй 8 төсөл, арга хэмжээг багцлан нэг төсөл, арга хэмжээ болгон төлөвлөсөн байна.



## ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

### Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавьж, төсвийг батлах
2. Олон нийтийн цагдаагийн цалин, НДШ-ийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд төлөвлөн зарцуулах

### Аймгийн Засаг даргад:

1. Төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасан шалгуурт нийцүүлэн боловсруулах
2. Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup>.2-т заасан төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг төсвийн төсөлд тусгах
3. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4 “Санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах” –т заасныг мөрдөж төсөл, арга хэмжээ бүрээр төлөвлөх
4. Төрийн албан хаагчдын улирлын үр дүнгийн урамшууллыг Засгийн газраас тогтоосны дагуу цалингийн зардалд төлөвлөх
5. Татварын орлогыг урьд онуудын татварын авлага, тайлант оны ногдуулалтад үндэслэн төлөвлөх.
6. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн төлөвлөх



Хавсралт 1

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төрөл	Эх үүсвэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг /мян.төг/	2026 онд санхүүжих дүн /мян.төг/	Бодлогын баримт бичигтэй нийцсэн эсэх		Зураг төсөв, Техникийн тодорхойлолттой эсэх	Магадлалаар баталгаажсан эсэх	Шаардлагатай төсөл, арга хэмжээнд урсгал зардал тооцсон эсэх
				Эхлэх	Дуусах			Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	Аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөө			
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Аймгийн татварын хэлтсийн засвар	Их засвар	ОНТХО	2026	2026	94.0	94.0	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	Хамаарахгүй
2	Мэдээлэл сургалтад ашиглах ухаалаг дэлгэц (ЭМДХ)	Тоног төхөөрөмж	ОНТХО	2026	2026	7.0	7.0	Тийм	Үгүй	Үгүй	Хамаарахгүй	Хамаарахгүй
3	Хан Хэнтий чуулгын тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж	ОНТХО	2026	2026	120.0	120.0	Тийм	Үгүй	Тийм	Хамаарахгүй	Хамаарахгүй
4	Аймгийн татварын хэлтсийн тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж	ОНТХО	2026	2026	40.0	40.0	Тийм	Үгүй	Тийм	Хамаарахгүй	Хамаарахгүй
5	Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасагт шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил	Тоног төхөөрөмж	ОНТХО	2026	2026	38.0	38.0	Тийм	Тийм	Үгүй	Хамаарахгүй	Хамаарахгүй
6	Сумын төвийн 0.4 кВ ЦДАШ-ын өргөтгөл (Батширээт)	Барилга байгууламж	ОНТХО	2026	2026	318.5	318.5	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Хамаарахгүй
7	Спорт цогцолборын тоног төхөөрөмж (Дадал сум)	Тоног төхөөрөмж	ОНТХО	2026	2026	32.0	32.0	Үгүй	Үгүй	Тийм	Хамаарахгүй	Хамаарахгүй
8	Соёлын төвийн хэсэгчилсэн засвар (Дархан сум)	Их засвар	ОНТХО	2026	2026	98.0	98.0	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Хамаарахгүй
9	0.4 кВт-ын ЦДАШугам сүлжээ татах (Норовлин сум)	Барилга байгууламж	ОНТХО	2026	2026	100.0	100.0	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Хамаарахгүй
10	Гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлэх (Хэрлэн сум)	Барилга байгууламж	ОНТХО	2026	2027	1,000.0	500.0	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй
11	Аймгийн өвс тэжээлийн аюулагийн нөөцийн агуулах саравчийн засвар (Хэрлэн сум)	Их засвар	ОНТХО	2026	2026	151.9	151.9	Үгүй	Тийм	Тийм	Үгүй	Хамаарахгүй
12	Ерөнхий боловсролын сургуулийн тоног, төхөөрөмж, Хэрлэн 4-дүгээр сургууль (Хэрлэн сум)	Тоног төхөөрөмж	ОНТХО	2026	2026	35.0	35.0	Тийм	Тийм	Үгүй	Хамаарахгүй	Хамаарахгүй
13	Шинэ суурьшлын бүсэд цахилгаан хангамж татах /Батноров сум/	Барилга байгууламж	ОНХС	2026	2027	301.0	150.5	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Хамаарахгүй
14	Ахмадын байрны барилгын их засвар (Дадал сум)	Их засвар	ОНХС	2026	2026	258.3	129.1	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй	Хамаарахгүй
15	Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажил /8 зураг төсөл/	ТЭЗҮ	ОНХС	2026	2026	447.0	447.0	Тийм	Үгүй	3 үгүй	Хамаарахгүй	Хамаарахгүй



16	Цэвэр усны шугам сүлжээг хийн даралтаар цэвэрлэх компрессор /Чингис хотын ундны усны 41 км шугам сүлжээг цэвэрлэж иргэдийн эрүүл ахуйн хэрэглээний усаар хангана/	Тоног төхөөрөмж	ОНХС	2026	2026	60.0	60.00	Тийм	Тийм	Үгүй	Хамаарахгүй	Хамаарахгүй
17	Нүүрс тээврийн чиргүүлтэй автомашин (Хэрлэн сум)	Тоног төхөөрөмж	ОНХС	2026	2026	300.0	300.0	Тийм	Үгүй	Үгүй	Хамаарахгүй	Хамаарахгүй
18	Хот тохижилтын автомашин, техник (Хэрлэн сум)	Тоног төхөөрөмж	ОНХС	2026	2026	530.0	530.0	Тийм	Үгүй	Тийм	Хамаарахгүй	Үгүй
19	Хуучин сургуулийн барилгын их засвар (Жаргалтхаан сум)	Их засвар	Их засвар	2026	2027	280.0	229.2	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Хамаарахгүй
20	Хуучин сургуулийн барилгын их засвар (Дэлгэрхаан сум)	Их засвар	Их засвар	2026	2027	250.0	175.0	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Хамаарахгүй
21	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын их засвар (Хэнтий, Баянмөнх сум)	Их засвар	Их засвар	2026	2026	295.4	211.2	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Хамаарахгүй
22	Монгол хатдын өргөөний их засвар (Баян-Адарга сум)	Их засвар	Их засвар	2026	2026	100.0	100.0	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Хамаарахгүй
23	Авто замын засвар, шинэчлэлт (Хэрлэн сум)	Барилга байгууламж	Замын сан	2026	2026	1,681.2	1,681.2	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Хамаарахгүй
24	Хот тохижилтын тоног төхөөрөмж (Хэрлэн, Баян-Адарга, Бор-Өндөр)	Тоног төхөөрөмж	Замын сан	2026	2026	186.8	186.8	Үгүй	Үгүй	Тийм	Хамаарахгүй	Үгүй
<b>НИЙТ</b>				<b>24</b>	<b>24</b>	<b>6,724.1</b>	<b>5,734.4</b>					

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг,  
Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхарт  
Утас: +976 70562112  
И-мэйл хаяг: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn), Веб сайт: [www.audit.mn](http://www.audit.mn)